

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\215\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

᠒᠐24.02.25 № 01/139  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН  
НОМЫН САНГИЙН ДАРГА  
Б.ЗОРИГТБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн нийтийн номын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Тус байгууллага нь 2023 онд "Хүүхэд бүр уншигч жил" болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 5 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэн төсвийг хэмнэлттэй зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,399,569.07</b>	<b>49,078,922.11</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	9,001,530.07	12,974,003.11
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	9,001,530.07	12,974,003.11
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	9,001,530.07	12,974,003.11
31211	Төрийн сангийн харилцах	9,001,530.07	12,974,003.11
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,398,039.00	36,104,919.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13,398,039.00	36,104,919.00
35410	Бичиг хэргийн материал	242,400.00	3,977,900.00
35420	Аж ахуйн материал	13,155,639.00	32,127,019.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,134,472,965.98</b>	<b>2,100,997,235.17</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,134,472,965.98	2,100,997,235.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,100,369,209.19	2,068,073,479.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,901,075,852.00	1,901,075,852.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(82,499,789.88)	(119,339,467.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,500,000.00)	(21,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,729,691.37	105,268,691.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,904,089.73)	(47,918,398.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,791,910.81	160,631,910.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,905,445.36)	(45,019,173.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,209,773.09	2,529,773.09
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,145,527.77)	(2,211,681.80)
39217	Ном	102,016,834.66	113,055,973.66
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	34,103,756.79	32,923,755.51
39301	Програм хангамж	6,430,000.00	6,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,751,249.89)	(4,806,249.85)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,550,008.00	33,550,008.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,125,001.32)	(2,250,002.64)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,156,872,535.05</b>	<b>2,150,076,157.28</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,325,895.00</b>	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,325,895.00	
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,325,895.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,325,895.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,149,546,640.05</b>	<b>2,150,076,157.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,149,546,640.05	2,150,076,157.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	374,082,784.22	374,082,784.22
51101	Өмч: - төрийн	374,082,784.22	374,082,784.22
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,055,642,757.92	1,056,172,275.15
51210	Өмнөх үеийн үр дүн	1,103,052,577.21	1,055,642,757.92
51220	Тайлант үеийн үр дүн	(47,409,819.29)	529,517.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	719,821,097.91	719,821,097.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,156,872,535.05</b>	<b>2,150,076,157.28</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>310,800,635.00</b>	<b>468,512,585.85</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,252,500.00</b>	<b>29,319,300.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,252,500.00	29,319,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,002,500.00	29,319,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,188,700.00	6,272,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,813,800.00	23,047,300.00
120009	Бусад орлого	250,000.00	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>304,548,135.00</b>	<b>439,193,285.85</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	176,337,500.00	255,557,420.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,337,500.00	255,557,420.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,750,000.00	42,806,265.85
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		39,237,865.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,750,000.00	3,568,400.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	113,460,635.00	140,829,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	113,460,635.00	140,829,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>358,210,454.29</b>	<b>467,983,068.62</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>358,210,454.29</b>	<b>467,983,068.62</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	354,841,869.15	453,370,854.26
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	136,409,539.22	194,210,801.31
210101	Үндсэн цалин	110,029,542.50	131,577,428.53
210102	Нэмэгдэл	16,492,464.52	34,238,810.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,229,000.00	11,483,500.00
210104	Урамшуулал	1,658,532.20	16,911,061.93
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,091,643.73	24,912,819.50
210201	Тэтгэврийн даатгал	11,665,275.35	18,092,532.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,372,385.44	1,705,087.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,091,188.30	1,364,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	269,344.86	340,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,693,449.78	3,409,900.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	102,604,795.00	124,000,460.64
210301	Гэрэл, цахилгаан	5,606,025.00	9,719,781.50
210302	Түлш, халаалт	94,690,043.00	111,466,801.34
210303	Цэвэр, бохир ус	2,308,727.00	2,813,877.80
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,929,866.84	9,028,270.00
210401	Бичиг хэрэг	954,750.00	1,533,800.00
210402	Тээвэр, шатахуун	581,132.00	1,097,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,541,744.84	2,312,640.00
210404	Ном, хэвлэл	701,400.00	976,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,840.00	3,107,730.00
2105	<b>Нормативт зардал</b>	300,250.00	713,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,250.00	713,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,060,950.00	4,392,680.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	618,100.00	939,400.00
210604	Урсгал засвар	442,850.00	3,453,280.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	212,000.00	832,000.00
210702	Дотоод албан томилголт	212,000.00	832,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,243,420.00	19,711,025.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,243,420.00	19,004,525.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		706,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	73,989,404.36	75,568,997.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,379,210.00	6,355,128.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,610,194.36	69,213,869.81
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,368,585.14	14,612,214.36
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	840,000.00	14,608,970.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,333,290.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		12,775,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	840,000.00	500,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,907,752.58	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,907,752.58	
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	620,832.56	3,244.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	620,832.56	3,244.36
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(47,409,819.29)</b>	<b>529,517.23</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(47,409,819.29)</b>	<b>529,517.23</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>307,986,835.00</b>	<b>445,465,285.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,438,700.00</b>	<b>6,272,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,438,700.00</b>	<b>6,272,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,188,700.00	6,272,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,188,700.00	6,272,000.00
120009	Бусад орлого	250,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>304,548,135.00</b>	<b>439,193,285.85</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>176,337,500.00</b>	<b>255,557,420.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,337,500.00	255,557,420.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,750,000.00</b>	<b>42,806,265.85</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		39,237,865.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,750,000.00	3,568,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>113,460,635.00</b>	<b>140,829,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	113,460,635.00	140,829,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>287,909,004.93</b>	<b>426,090,973.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>287,909,004.93</b>	<b>426,090,973.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>284,620,419.79</b>	<b>411,478,759.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>136,409,539.22</b>	<b>194,210,801.31</b>
210101	Үндсэн цалин	110,029,542.50	131,577,428.53
210102	Нэмэгдэл	16,492,464.52	34,238,810.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,229,000.00	11,483,500.00
210104	Урамшуулал	1,658,532.20	16,911,061.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,091,643.73</b>	<b>24,912,819.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,665,275.35	18,092,532.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,372,385.44	1,705,087.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,091,188.30	1,364,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	269,344.86	340,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,693,449.78	3,409,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>95,278,900.00</b>	<b>131,326,355.64</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,606,025.00	9,719,781.50
210302	Түлш, халаалт	87,364,148.00	118,574,270.14
210303	Цэвэр, бохир ус	2,308,727.00	3,032,304.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,925,116.84</b>	<b>6,549,770.00</b>
210401	Бичиг хэрэг	989,750.00	1,499,800.00
210402	Тээвэр, шатахуун	521,132.00	1,097,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,541,744.84	2,312,640.00
210404	Ном, хэвлэл	701,400.00	976,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	171,090.00	663,230.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>300,000.00</b>	<b>700,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	700,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,346,350.00</b>	<b>18,985,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		8,285,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	846,350.00	1,199,900.00
210604	Урсгал засвар	500,000.00	9,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>212,000.00</b>	<b>832,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	212,000.00	832,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,612,420.00</b>	<b>22,873,520.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,612,420.00	21,476,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,396,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,444,450.00</b>	<b>11,088,493.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,444,450.00	11,088,493.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,288,585.14</b>	<b>14,612,214.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>760,000.00</b>	<b>14,608,970.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,333,290.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		12,775,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,907,752.58</b>	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,907,752.58	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>620,832.56</b>	<b>3,244.36</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	620,832.56	3,244.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>20,077,830.07</b>	<b>19,374,312.04</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,076,300.00</b>	<b>15,401,839.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,076,300.00</b>	<b>15,401,839.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,076,300.00</b>	<b>15,401,839.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,076,300.00	15,401,839.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,076,300.00)</b>	<b>(15,401,839.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>9,001,530.07</b>	<b>3,972,473.04</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>9,001,530.07</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9,011,530.07</b>	<b>12,974,003.11</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-47,409,819.29	-47,409,819.29
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,055,642,757.92	2,149,546,640.05
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,055,642,757.92	2,149,546,640.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,055,642,757.92	2,149,546,640.05
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	529,517.23	529,517.23
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,056,172,275.15	2,150,076,157.28

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	451,844,120.00	441,489,568.45	10,354,551.55	98.0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	451,844,120.00	441,489,568.45	10,354,551.55	98.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	438,300,400.00	426,880,598.45	11,419,801.55	97.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	203,074,300.00	194,210,801.31	8,863,498.69	96.0
210101	Үндсэн цалин	134,170,200.00	131,577,428.53	2,592,771.47	98.1
210102	Нэмэгдэл	31,620,800.00	34,238,810.85	(2,618,010.85)	108.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,288,000.00	11,483,500.00	1,804,500.00	86.4
210104	Урамшуулал	23,995,300.00	16,911,061.93	7,084,238.07	70.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,681,000.00	24,912,819.50	1,768,180.50	93.4
210201	Тэтгэврийн даатгал	18,638,100.00	18,092,532.00	545,568.00	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,010,800.00	1,705,087.50	305,712.50	85.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,608,900.00	1,364,400.00	244,500.00	85.0
210204	Ажилгүйдлийн даатгал	402,000.00	340,900.00	61,100.00	85.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,021,200.00	3,409,900.00	611,300.00	85.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогмол зардал</b>	137,329,600.00	131,326,355.64	6,003,244.36	96.0
210301	Гэрэл, цахилгаан	10,640,400.00	9,719,781.50	920,618.50	91.3
210302	Түлш, халаалт	120,488,800.00	118,574,270.14	1,914,529.86	98.4
210303	Цэвэр, бохир ус	6,200,400.00	3,032,304.00	3,168,096.00	49.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,600,000.00	14,541,609.00	58,391.00	99.6
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,499,800.00	200.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	1,097,600.00	2,400.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,312,640.00	87,360.00	96.4
210404	Ном, хэвлэл	9,000,000.00	8,968,339.00	31,661.00	96.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	663,230.00	(63,230.00)	110.5
2105	<b>Нормативт зардал</b>	700,000.00	700,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,395,100.00	26,395,000.00	(5,999,900.00)	129.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,695,100.00	15,695,100.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200,000.00	1,199,900.00	100.00	100.0
210604	Урсгал засвар	3,500,000.00	9,500,000.00	(6,000,000.00)	271.4
2107	<b>Томилот, зочны зардал</b>	1,000,000.00	832,000.00	168,000.00	83.2
210702	Дотоод албан томилот	1,000,000.00	832,000.00	168,000.00	83.2
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,891,400.00	22,873,520.00	(982,120.00)	104.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хур	20,061,400.00	21,476,920.00	(1,415,520.00)	107.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,830,000.00	1,396,600.00	433,400.00	76.3
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,629,000.00	11,088,493.00	1,540,507.00	88.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,629,000.00	11,088,493.00	1,540,507.00	88.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,543,720.00	14,608,970.00	(1,065,250.00)	108.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,543,720.00	14,608,970.00	(1,065,250.00)	108.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,333,290.00	(1,333,290.00)	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,775,720.00	12,775,680.00	40.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	500,000.00	268,000.00	65.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	435,624,820.00	402,659,020.00	32,965,800.00	92.4
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	435,624,820.00	396,387,020.00	39,237,800.00	91.0
122005	Орон нутгийн төсвөөс	435,624,820.00	396,387,020.00	39,237,800.00	91.0
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		6,272,000.00	(6,272,000.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,272,000.00	(6,272,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,001,530.07	(9,001,530.07)	
5	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		12,974,003.11	(12,974,003.11)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Нийтийн номын сан нь иргэдэд ном хэвлэлээр үйлчлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг Соёл Урлагийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд “Хүүхэд бүр уншигч жил” болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 5 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 91,0 хувиар биелүүлж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Нийтийн номын сан үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн нийтийн номын сангийн үйл ажиллагаанд 2023 оны 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит шалгалтын баг ажиллаж 96,0 хувьтай үнэлэгдсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,796.3 мянган төгрөгөөр буюу 0,4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	9,001.5	12,974.0	3,972.4
<b>Авлага</b>			
<b>Урьдчилгаа</b>			
<b>Бараа материал</b>	13,398.0	36,104.9	22,706.8
<b>Үндсэн хөрөнгө</b>	2,134,472.9	2,100,997.2	-33,475.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,156,872.5</b>	<b>2,150,076.1</b>	<b>-6,796.3</b>
<b>Өр төлбөр</b>	7,325.8	0	-7,325.8
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	2,149,546.6	2,150,076.1	529.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,156,872.5</b>	<b>2,150,076.1</b>	<b>-6,796.3</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,972.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс зэргийг хэмнэснээс шалтгаалан өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 22,706.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалыг нөөцлөн авч, үлдэгдэл өссөнтэй холбоотой байна. Үүнд: Тус номын сан нь 2023 онд төсвийн хөрөнгөөр 47,633.8 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн бараа материал, сэлбэг хэрэгсэл худалдан авсан, мөн Соёлын яамнаас 2,711.0 мянган төгрөгийн номын ялтас авсан зэргээс шалтгаалан үлдэгдэл өссөн байна.

Номын сангийн өөрийн үйл ажиллагаанд бараа материал данснаас 27,637.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө данс 33,475.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн хэмжээ нөлөөлсөн байна. 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр 7,090.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 7,991.8 мянган төгрөгийн ном, өв соёл танхимын тохижилтод 320.0 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг домбо зэрэг нийт 15,401.8 мянган төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.

Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 16,539.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 750.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил авсан.

Үндсэн хөрөнгийн номын фонд дансанд иргэд болон байгууллагаас үнэ төлбөргүй 3,047.3 мянган төгрөгийн номыг орлогоор бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансанд 2023 онд байгуулсан элэгдэл 69,213.9 мянган төгрөг, элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 311,014.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 140,829.6 мянган төгрөг, нийт зарлагыг 451,844.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 451,844.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 451,844.1 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 255,557.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 140,829.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр бүрдүүлсэн байна.

Төв аймгийн нийтийн номын сан нь 2023 онд үр дүнд суурилсан санхүүжилт дансанд нэмэлтээр 39,237.8 мянган төгрөгийг Соёлын яамны санхүүжилтээр хүлээн авсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 441,489.6 мянган төгрөг буюу 96,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 10,351.3 сая төгрөгөөр, үүнээс урамшуулал цалин 8,862.8 мянган төгрөг тус тус хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	244,559.6	233,690.8	10,868.8	95,5
2	71702-80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	6,091.9	6,091.9		100%
3	71702-81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	39,237.9	38,881.4	356.5	99,09%
4	71702-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	13,543.7	13,275.6	37.7	98,02%
5	71702-83603 Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	8,723.3	8,723.3		100%
6	71702-80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	140,829.6	140,826.3	3,244.4	100%
	дүн				

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Нийтийн номын сан нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71702-80101	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны зардал	95,52%	197,842.6	188,979.7
2	71702-80215	2023-12-31	Эрдэм шинжилгээ, судалгааны зардал	100%	6,091.9	6,091.9
3	71702-81855	2023-12-31	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	99,09%	39,237.9	38,881.4
4	71702-80802	2023-12-31	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	98,02%	13,543.7	13,275.6
5	71702-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	100%	8,723.3	8,723.3
6	71702-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	100%	140,829.6	140,826.3

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нийтийн номын сан нь 2023 оны худалдан авах ажиллагааны 11 зүйлтэй төлөвлөгөөг Төв аймгийн худалдан авах ажиллагааны газраар батлуулан ажилласнаар аймгийн худалдан авах ажиллагааны газрын зөвшөөрөлтэй Нар сар ХХК-аас бичиг хэргийн материал, Мандуухай ХХК-аас аж ахуйн материалыг авсан. Үндсэн хөрөнгө болох номыг Интер-Ном ХХК, болон Аз хур ХХК-аас нийлүүлсэн байна.

Худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах авто машин ашиглалтын анхан шатны бүртгэлийг сайжруулах, шилэн дансанд мэдээллийг тогтмол оруулж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 190,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 3,800.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,040.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин нэмэгдэл урамшуулалтай холбоотой зардал, бараа ажил үйлчилгээний зардлыг тус тус хэмнэж ажилласан байна.

. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 8,862.9 мянган төгрөгөөр
- Бараа ажил үйлчилгээний зардлыг 1,689.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн нийтийн номын сангийн 2023 оны санхүүгийн тайлангаар Шилэн дансны хөтлөлтийн хуулийн хугацаанд мэдээллийг сар бүр байршуулан нийт 163 мэдээлэл байршуулахаас 160 мэдээлэл хугацаанд нь байршуулан 3 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан 98,2%-тай ажилласан байна.

Төв аймгийн нийтийн номын сан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 4.4-д "5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, хаяг", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй боловч дээрх хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээллийг хоцруулахгүй байхыг анхааруулан зөвлөмж бичлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Нийтийн номын сангийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1,113.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулах зөвлөмж өгсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянан 1 алдааг залруулах зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>					
<b>Албан шаардлага</b>	1	2,858.0	1	2,858.0	100
<b>Зөвлөмж</b>	3	16,184.4	3	16,184.4	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>19,042.4</b>	<b>4</b>	<b>19,042.4</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Төв аймгийн Нийтийн номын сангийн ном болон эд хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, эд хариуцагчийн орон тооны асуудлыг холбогдох яам газарт тавьж шийдвэрлүүлсэн эсэхэд анхаарал хандуулах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,113.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,113.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

Төв аймгийн нийтийн номын сангийн 2023 оны авто машин ашиглалтын бүртгэл, паспортыг хангамжийн бараа материалын тайлантай тулган шалгахад нийт 1,113.0 мянган төгрөгийн сэлбэг, шатахууны зарцуулалтын бичилт хийгдээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 71 тоот тушаалаар батлагдсан техник ашиглалтын хувийн хэрэг хөтлөх журмыг мөрдөж ажиллаагүй ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 5.1 Төлбөрийн акт

### 5.2 Албан шаардлага

### 5.3 Зөвлөмж

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авто машины хувийн хэрэгт тухайн авто машины зарцуулсан шатах тослох материал, урсгал болон их засварын зардлуудыг бүртгээгүй	1	1,113.0	1	1,113.0			1	1,113.0				
Дүн	1	1,113.0	1	1,113.0			1	1,113.0				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 163 мэдээлэл оруулахаас 160 мэдээлэл хугацаанд оруулж 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1	25,972.0					1	25,972.0
Дүн	1	25,972.0					1	25,972.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	25,972.0					1	25,972.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)